

ДЭМБ-ЫН ТАМХИНЫ  
ХЯНАЛТЫН СУУРЬ  
КОНВЕНЦ




5.3 дугаар зүйлийг  
хэрэгжүүлэх  
Удирдамж



**FCTC**

WHO FRAMEWORK CONVENTION  
ON TOBACCO CONTROL



## ДЭМБ-ЫН ТАМХИНЫ ХЯНАЛТЫН СУУРЬ КОНВЕНЦ

### 5.3 дугаар зүйлийг хэрэгжүүлэх удирдамж:

“Тамхины хяналтын талаарх  
нийгмийн эрүүл мэндийн бодлогыг  
тамхи үйлдвэрлэгчийн  
худалдааны болон бусад  
уламжлалт ашиг сонирхлоос  
хамгаалах тухай”

Оролцогч талуудын Бага хурлын гуравдугаар (шийдвэр дугаар FCTC/COP3(7))  
хуралдаанаар баталсан

Эх хувилбартай дараах хаягаар танилцана уу:

<https://fctc.who.int/publications/m/item/guidelines-for-implementation-of-article-5.3>

## **ДЭМБ-ЫН ТХСК-ИЙН 5.3 ДУГААР ЗҮЙЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДАМЖ**

### **ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТАЛААРХ НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БОДЛОГЫГ ТАМХИ ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ХУДАЛДААНЫ БОЛОН БУСАД УЛАМЖЛАЛТ АШИГ СОНИРХЛООС ХАМГААЛАХ ТУХАЙ**

#### **УДИРТГАЛ**

Тамхины хяналтын үйл явц дахь ил тод байдлын талаар ДЭМБ-ын Ерөнхий Чуулганы WNA54.18 шийдвэрт Тамхины үйлдвэрлэлийн баримт бичгийн шинжээчдийн хорооны дүгнэлтээс иш татахдаа "тамхи үйлдвэрлэгч нь тамхины тархалттай тэмцэх нийгмийн эрүүл мэндийн бодлогыг хэрэгжүүлэх засгийн газрын болон ДЭМБ-ын үүргийг сааруулах зорилготойгоор олон жилийн туршид үйл ажиллагаа явуулж ирсэн" гэжээ.

ДЭМБ-ын Тамхины хяналтын суурь конвенцийн Удиртгал хэсэгт Оролцогч талууд<sup>1</sup> нь "тамхины хяналтын чиглэлээрх хүчин чармайлтыг сулруулах буюу сааруулах тамхи үйлдвэрлэгчийн аливаа оролдлогод сэрэмжтэй, тамхины хяналтын хүчин чармайлтад сөрөг нөлөө үзүүлж буй тамхи үйлдвэрлэгчийн үйл ажиллагааны талаар мэдээлэлтэй байх шаардлагатай" гэж дурджээ.

Түүнчлэн, Конвенцийн 5.3 дугаар зүйлд "Оролцогч талууд нь тамхины хяналтын чиглэлээрх нийгмийн эрүүл мэндийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэхдээ тамхи үйлдвэрлэгчийн худалдааны болон бусад уламжлалт ашиг сонирхлоос нийгмийн эрүүл мэндийн бодлогыг үндэсний хууль тогтоомжийн дагуу хамгаалах арга хэмжээ авч хэрэгжүүлэх"-ийг шаардсан байдаг.

Конвенцийн Оролцогч талуудын Бага хурлаас FCTC/COP2(14) шийдвэрээр Конвенцийн 5.3 дугаар зүйлийг хэрэгжүүлэх удирдамжийг боловсруулах ажлын хэсгийг байгуулсан билээ.

Оролцогч талуудын тамхины хяналтын бодлого тодорхойлох, хэрэгжүүлэх бүрэн эрхээс үл хамааран Оролцогч талууд нь үндэсний хууль тогтоомжийн хүрээнд эдгээр удирдамжийг аль болох өргөн хүрээнд хэрэгжүүлнэ.

#### **Зорилго, хамрах хүрээ, хэрэгжилт**

Конвенцийн удиртгал хэсэг, тамхины хяналтын бодлогын талаарх заалтууд, ДЭМБ-ын Тамхины хяналтын конвенцийн үйл ажиллагааны зарчим хэсэгт заасанчлан улсын эзэмшлийн тамхи үйлдвэрлэгчийн төдийгүй тамхи үйлдвэрлэгчийн хөндлөнгийн оролцоо нь тамхины хяналтын бодлоготой холбоотой олон асуудлыг хамардаг гэдгийг удирдамжид хүлээн зөвшөөрсөн байдаг. Иймд Конвенцийн 5.3 дугаар зүйлийг хэрэгжүүлэх тухай энэхүү удирдамжийг ашиглах нь улс орнуудын тамхины хяналтын бодлого, Конвенцийн хэрэгжилтэд чухал нөлөө үзүүлэх юм.

Энэхүү удирдамжийн зорилго нь тамхи үйлдвэрлэгчийн худалдааны болон бусад уламжлалт ашиг сонирхлоос тамхины хяналтыг хамгаалах хүчин чармайлтуудын үр дүнтэй, цогц байдлыг хангахад чиглэгдэнэ. Оролцогч талууд

<sup>1</sup> "Оролцогч талууд" гэдэг нь олон улсын гэрээг хүлээн зөвшөөрч байгаагаа илэрхийлсэн ба гэрээ соёрхон баталсан улс орон, олон улсын гэрээнд гарын үсэг зурах эрх бүхий бусад этгээд юм (Эх сурвалж: Нэгдсэн үндэстний байгууллагын гэрээний цуглуулга, <https://legal.un.org/ola/Default.aspx#signatories>)

нь тамхины хяналтын асуудлаарх нийгмийн эрүүл мэндийн бодлогод нөлөөлөх сонирхолтой байж болох, аль эсвэл нөлөөлөх чадавх бүхий засгийн газрын байгууллагуудад үүнд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх хэрэгтэй.

Удирдамжийн зорилт нь Конвенцийн 5.3 дугаар зүйлийн хүрээнд хүлээсэн хууль эрхзүйн үүргийг хангахад нь Оролцогч талуудад<sup>2</sup> дэмжлэг үзүүлэхэд оршино. Удирдамж нь тамхи үйлдвэрлэгчийн хөндлөнгийн оролцоог шийдвэрлэх талаарх Оролцогч талуудын туршлага, шинжлэх ухааны шилдэг нотолгоонд тулгуурласан болно.

Удирдамжийг Оролцогч талуудын тамхины талаарх нийгмийн эрүүл мэндийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд ашиглана. Мөн уг бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх, зохион байгуулах, хэрэгжилтийг хангахад оролцож буй, оролцох боломж бүхий хувь хүн, байгууллага болон хуулийн этгээд хэрэглэнэ.

Энэхүү удирдамжийг Оролцогч талын эрх мэдэлд буй газрын албан тушаалтнууд, үндэсний, мужийн, орон нутгийн буюу бусад төрийн болон холимог өмчийн байгууллагын ажилтнууд, төлөөлөгчид ба тэдний өмнөөс үйл ажиллагаа явуулж буй этгээд ашиглана. Тамхины хяналтын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, нийгмийн эрүүл мэндийн бодлогыг тамхи үйлдвэрлэгчдийн ашиг сонирхлоос хамгаалах үүрэгтэй гүйцэтгэх, хууль тогтоох, шүүх засаглалын байгууллагууд хариуцлага хүлээх үүрэгтэй.

Тамхины хяналтын арга хэмжээ боловсруулах, хэрэгжүүлэхэд, Ялангуяа Конвенцийн Оролцогч талууд хэрэгжүүлэх шаардлагатай үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох тамхи үйлдвэрлэгчийн өргөн хүрээтэй стратеги, аргуудын баримт нотолгоо олон байдаг. Энэхүү удирдамжид зөвлөмж болгож буй арга хэмжээнүүд нь тамхи үйлдвэрлэгчийн төдийгүй тамхины үйлдвэрлэгчийн ашиг сонирхлын төлөө ажиллах сонирхолтой байгууллага, хувь хүний хөндлөнгийн оролцооноос хамгаалахад чиглэгдэнэ.

Конвенцийн 5.3 дугаар зүйлийн зорилтуудыг хангахын тулд Оролцогч талууд энэхүү удирдамжид зөвлөмж болгож буй арга хэмжээг өргөн хүрээнд хэрэгжүүлэх шаардлагатай бөгөөд өөрсдийн өвөрмөц нөхцөл байдалдаа нийцүүлэн удирдамжид санал болгосон арга хэмжээнээс бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг шаардаж байна.

## **БАРИМТЛАХ ЗАРЧИМ**

**Зарчим 1. Нийгмийн эрүүл мэндийн бодлогын болон тамхи үйлдвэрлэгчийн ашиг сонирхлын хооронд зарчмын ялгаатай, эвлэрүүлж үл болох зөрчил байдаг.**

Тамхи үйлдвэрлэгч нь донтуулах, өвчлөл нас баралтад хүргэх, ядуурлыг нэмэгдүүлэх зэрэг нийгмийн олон сөрөг асуудалд хүргэдэг болох нь шинжлэх ухаанаар нотлогдсон бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, хөхиүлэн дэмждэг тул Оролцогч талууд тамхины хяналтын чиглэлээр нийгмийн эрүүл мэндийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг тамхи үйлдвэрлэгчээс хамгаалах шаардлагатай.

---

<sup>2</sup> Энэхүү удирдамж нь мөн бүсийн эдийн засгийн нэгдсэн байгууллагуудад хамаарна.

**Зарчим 2. Оролцогч талууд нь тамхи үйлдвэрлэгч болон тэдний ашиг сонирхлын төлөө ажиллаж буй этгээдтэй харьцахдаа ил тод, хариуцлагатай байх зарчим баримтална.**

Оролцогч талуудын тамхины хяналтын буюу нийгмийн эрүүл мэндийн асуудлаарх тамхи үйлдвэрлэгчтэй харьцах үйл ажиллагаа нь ил тод, хариуцлагатай байна.

**Зарчим 3. Оролцогч талууд нь тамхи үйлдвэрлэгч болон тэдний ашиг сонирхлын төлөө ажиллаж буй этгээдийн ил тод, хариуцлагатай зарчмаар ажиллах, үйл ажиллагаа явуулахыг шаардана.**

Тамхи үйлдвэрлэгч нь Оролцогч талуудыг энэхүү удирдамжийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардагдах мэдээллээр хангана.

**Зарчим 4. Тамхи үйлдвэрлэгчийн бүтээгдэхүүн нь амь насанд аюултай тул бизнесийн үйл ажиллагаа эхлэх буюу эрхлэх хөшүүргээр тамхи үйлдвэрлэгчид дэмжлэг үзүүлэхийг хориглоно.**

Тамхи үйлдвэрлэгчид давуу тал олгох нь тамхины хяналтын бодлоготой зөрчилдөнө.

## **ЗӨВЛӨМЖ**

Тамхи үйлдвэрлэгчдийн нийгмийн эрүүл мэндийн бодлогод хөндлөнгөөс оролцох асуудлыг шийдвэрлэхэд дараах чухал арга хэмжээг зөвлөмж болгож байна:

- (1) Тамхин бүтээгдэхүүний донтуулах шинж чанар, хор уршгийн талаар болон Оролцогч талуудын тамхины хяналтын бодлогод тамхи үйлдвэрлэгчийн хөндлөнгийн оролцооны талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх;
- (2) Тамхи үйлдвэрлэгчтэй харьцах харилцааг хязгаарлах арга хэмжээ хэрэгжүүлэх, харилцааны ил тод байдлыг хангах;
- (3) Тамхи үйлдвэрлэгчтэй түншлэл тогтоох, заавал биелүүлэх албагүй буюу хэрэгжүүлэх боломжгүй гэрээ байгуулахаас татгалзах;
- (4) Засгийн газрын албан тушаалтан, ажилтны ашиг сонирхлын зөрчлөөс зайлсхийх;
- (5) Тамхи үйлдвэрлэгчээс үнэн зөв, ил тод мэдээлэл өгөхийг шаардах;
- (6) Тамхи үйлдвэрлэгчийн зүгээс "нийгмийн хариуцлага"- тай хэмээн тодотгосон үйл ажиллагаа явуулахыг буруушаах, зохицуулах;
- (7) Тамхи үйлдвэрлэгчид давуу эрх олгохгүй байх;
- (8) Төрийн эзэмшлийн тамхи үйлдвэрлэгчид бусад тамхи үйлдвэрлэгчийн нэгэн адил хандах.

Тамхины хяналтын талаарх нийгмийн эрүүл мэндийн бодлогыг тамхи үйлдвэрлэгчийн худалдааны болон бусад уламжлалт ашиг сонирхлоос хамгаалах чиглэлээр дор дурдсан арга хэмжээг хэрэгжүүлэхээр тохиролцов. Оролцогч талууд энэхүү удирдамжид дурдаагүй илүү хатуу бусад арга хэмжээг хэрэгжүүлэхийг дэмжих бөгөөд удирдамж дахь аливаа үйл ажиллагаа нь

Оролцогч талуудыг зөвлөмжид нийцүүлэн илүү хатуу шаардлага тавихад саад болохгүй.

**(1) Тамхин бүтээгдэхүүний донтуулах шинж чанар, хор уршгийн талаар болон Оролцогч талуудын тамхины хяналтын бодлогод тамхи үйлдвэрлэгчийн хөндлөнгийн оролцооны талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх**

Засгийн газрын бүх салбар, олон нийт нь тамхины хяналтын талаар нийгмийн эрүүл мэндийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд тамхи үйлдвэрлэгчийн өнгөрсөн болон одоо үеийн хөндлөнгийн оролцооны асуудлаар тодорхой мэдлэгтэй байвал зохино. Тамхины хяналтын суурь конвенцийг амжилттай хэрэгжүүлэхэд Ийм төрлийн хөндлөнгийн оролцоонд үр дүнтэй няцаалт өгөх шаардлагатай.

**Зөвлөмж**

- 1.1 Конвенцийн 12 дугаар зүйлийг харгалзан, Оролцогч талууд нь тамхины хяналтын талаар нийгмийн эрүүл - мэндийн бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэхэд тамхи үйлдвэрлэгчийн зүгээс хөндлөнгөөс оролцох талаарх стратеги, аргууд, нийгмийн эрүүл мэндийн бодлогыг 2006 тамхи үйлдвэрлэгчийн худалдааны болон бусад уламжлалт ашиг сонирхлоос хамгаалах шаардлага, тамхи, тамхин бүтээгдэхүүний донтуулах, хортой шинж чанарын талаар засгийн газрын бүх салбар, олон нийтэд мэдээлж, мэдлэгийг нь нэмэгдүүлэх шаардлагатай.
- 1.2 Мөн тамхи үйлдвэрлэгч өөрийг нь төлөөлөх буюу эрх ашгийг нь хамгаалах үйл ажиллагаанд хувь хүн, бүлэг, байгууллагуудыг ил, далд хэлбэрээр хэрхэн ашигладаг талаарх мэдлэгийг Оролцогч талууд нэмэгдүүлэх шаардлагатай.

**(2) Тамхи үйлдвэрлэгчтэй харьцах харилцааг хязгаарлах арга хэмжээ хэрэгжүүлэх, харилцааны ил тод байдлыг хангах**

Тамхины хяналтын талаар нийгмийн эрүүл мэндийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд Оролцогч талууд тамхи үйлдвэрлэгчтэй зайлшгүй харилцах шаардлага гарвал уг харилцаа нь хамтын ажиллагаа, түншлэлийн харилцаа биш гэдгийг тодорхой болгоно. Тамхи үйлдвэрлэгчийн зүгээс үүний эсрэг ойлголт төрүүлэх аливаа үйл ажиллагаа хэрэгжүүлбэл Оролцогч талууд ташаа ойлголт бий болохоос урьдчилан сэргийлэх, залруулах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

**Зөвлөмж**

- 2.1 Оролцогч талууд нь зөвхөн тамхины үйлдвэрлэл, тамхин бүтээгдэхүүнийг үр дүнтэй зохицуулахад шаардлагатай үед, зөвхөн тогтоосон хязгаарын хүрээнд тамхи үйлдвэрлэгчтэй харилцана.
- 2.2 Тамхи үйлдвэрлэгчтэй харилцах шаардлагатай үед Оролцогч талууд энэхүү үйл ажиллагааг ил тодоор хэрэгжүүлнэ. Боломжтой бол харилцааг олон нийтэд нээлттэй байдлаар, тухайлбал олон нийтэд мэдээлэл хийх, тайлагнах, зарлах зэрэг хэлбэрээр явуулна.

**(3) Тамхи үйлдвэрлэгчтэй түншлэл тогтоох, заавал биелүүлэх албагүй буюу хэрэгжүүлэх боломжгүй гэрээ байгуулахаас татгалзах**

Тамхи үйлдвэрлэгчийн ашиг сонирхол нь нийгмийн эрүүл мэндийн зорилтуудтай шууд зөрчилдөх учир нийгмийн эрүүл мэндийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх асуудлаар тамхи үйлдвэрлэгчтэй түншилж болохгүй.

### **Зөвлөмж**

- 3.1 Оролцогч талууд нь тамхи үйлдвэрлэгч болон тамхи үйлдвэрлэгчийн ашиг сонирхлын төлөө ажиллаж буй хуулийн этгээд, иргэдтэй түншлэл тогтоох, заавал биелүүлэх албагүй буюу хэрэгжүүлэх боломжгүй гэрээ байгуулах, сайн дурын тохиролцоо хийхийг хүлээн зөвшөөрөх, дэмжих, батлахыг хориглоно.
- 3.2 Оролцогч талууд нь тамхины хяналттай шууд болон шууд бусаар холбоотой санаачилга, залуучуудын болон олон нийтийн боловсролын үйл ажиллагаанд тамхи үйлдвэрлэгч оролцох, зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх, хэрэгжүүлэхийг хүлээн зөвшөөрөх, дэмжих, батлахыг хориглоно.
- 3.3 Оролцогч талууд нь хуулийн хүрээнд зайлшгүй хэрэгжүүлбэл зохих үйл ажиллагааг орлуулах зорилгоор тамхи үйлдвэрлэгчийн зүгээс санал болгож буй аргачлал буюу сайн дурын үйл ажиллагааг хэрэгжүүлэх дүрэм журмыг хүлээн зөвшөөрөх, дэмжих, батлахыг хориглоно.
- 3.4 Оролцогч талууд нь тамхи үйлдвэрлэгчийн буюу тамхи үйлдвэрлэгчтэй хамтран боловсруулсан тамхины хяналтын талаарх хууль тогтоомж буюу бодлого, туслалцаа үзүүлэх тухай саналыг хүлээн авах, дэмжлэг үзүүлэх, батлахыг хориглоно.

### **(4) Засгийн газрын албан тушаалтан, ажилтны ашиг сонирхлын зөрчлөөс зайлсхийх**

Тамхи үйлдвэрлэгчийн худалдааны болон бусад уламжлалт ашиг сонирхол бүхий байгууллага, иргэдийг тамхины хяналтын талаарх нийгмийн эрүүл мэндийн бодлогод оролцуулах нь сөрөг үр дагаварт хүргэдэг. Тамхины хяналтын чиглэлээр ажиллаж буй засгийн газрын албан тушаалтан, ажилтнуудыг ашиг сонирхлын зөрчлөөс хамгаалах тодорхой журам нь тамхи үйлдвэрлэгчийн хөндлөнгийн оролцооноос хамгаалах чухал арга юм.

Тамхи үйлдвэрлэгчийн зүгээс Засгийн газрын байгууллага, албан тушаалтан, ажилтнуудад санал болгосон төлбөр, бэлэг, үйлчилгээ, мөнгөн болон мөнгөн бус туслалцаа, судалгааны ажлын санхүүжилт зэрэг нь ашиг сонирхлын зөрчил үүсгэнэ. Энэхүү дэмжлэг, туслалцааны хариуд асуудлыг нааштайгаар авч үзэх тухай амлалт өгөөгүй хэдий ч ашиг сонирхлын зөрчил үүсдэг, учир нь НҮБ-ын Ерөнхий чуулганы Төрийн албан хаагчдын ёс зүйн дүрэм, Засгийн газрын болон бүсийн эдийн засгийн асуудлаарх байгууллагуудын тодорхойлсончлон хувийн ашиг сонирхол албан үүрэг хариуцлагад нөлөөлж болзошгүй байдаг.

### **Зөвлөмж**

- 4.1 Оролцогч талууд нь тамхины хяналтын талаар нийгмийн эрүүл мэндийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцогч засгийн газрын албан Оролцов тушаалтнууд, ажилтнууд, зөвлөх, гэрээт ажилтан зэрэг бүх хүмүүст хамаарах ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, мэдээлэх бодлого хэрэгжүүлнэ.

- 4.2 Оролцогч талууд нь тамхи үйлдвэрлэгчтэй харьцахдаа дагаж мөрдөх хэм хэмжээг тодорхойлсон төрийн албан хаагчдын ёс зүйн дүрэм боловсруулж батлан, хэрэгжүүлнэ.
- 4.3 Оролцогч талууд нь тамхины хяналтын бодлоготой ашиг сонирхлын зөрчилтэй тендерт оролцогч, нэр дэвшигчтэй тамхины хяналтын асуудлаар нийгмийн эрүүл мэндийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа ажил үйлчилгээ гүйцэтгэх гэрээ байгуулахыг хориглоно.
- 4.4 Оролцогч талууд нь тамхины хяналтын асуудлаар нийгмийн эрүүл мэндийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцож байсан болон оролцож буй төрийн албан хаагчдыг тамхи үйлдвэрлэгчийн ашгийн төлөө буюу ашгийн төлөө бус аливаа үйл ажиллагаанд оролцох болбол энэ талаар ажил үүргээ орхисноос хойш тодорхой хугацаанд өөрийн байгууллагад мэдээлэхийг шаардсан тодорхой бодлого боловсруулах ёстой.
- 4.5 Оролцогч талууд тамхины хяналтын талаар нийгмийн эрүүл мэндийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцох төрийн байгууллагын албан тушаалд нэр дэвшигч нь тамхи үйлдвэрлэгчтэй холбоотой ашгийн төлөө болон ашгийн төлөө бус аливаа үйл ажиллагаанд оролцож байсан болон оролцож байгаа талаар мэдэгдэх тухай тодорхой бодлого боловсруулна.
- 4.6 Оролцогч талууд нь засгийн газрын албан тушаалтнуудыг тамхи үйлдвэрлэгчийн шууд ашиг сонирхлоос зайлсхийх, мэдээлэхийг шаардана.
- 4.7 Засгийн газрын байгууллагууд, этгээдүүд Оролцогч талын улсын эзэмшлийн үйлдвэрлэгчийг төрийн мэдэлд авах ашиг сонирхлыг хариуцаж байгаагаас бусад тохиолдолд тамхины үйлдвэрлэгчтэй холбоотой санхүүгийн ашиг сонирхолтой байхыг хориглоно.
- 4.8 Оролцогч талууд нь тамхи үйлдвэрлэгчид ажил эрхэлж байгаа буюу тамхи үйлдвэрлэгчийн эрх ашгийн төлөө ажиллаж буй хуулийн этгээдийг тамхины хяналтын болон нийгмийн эрүүл мэндийн бодлого боловсруулдаг буюу хэрэгжүүлдэг засгийн газрын байгууллага, зөвлөл, зөвлөх бүлгийн гишүүн байхыг хориглоно.
- 4.9 Оролцогч талууд нь тамхи үйлдвэрлэгчид ажил эрхэлж байгаа буюу тамхи үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах сонирхолтой хуулийн этгээдийг Оролцогч талуудын Бага хурал, түүний төлөөлөх байгууллага буюу Оролцогч талуудын Бага хурлын шийдвэрээр байгуулагдсан ажлын хэсэг, бүлгийн уулзалт, хуралд төлөөлөгчөөр нэр дэвшүүлэхийг хориглоно.
- 4.10 Оролцогч талууд нь Засгийн газрын буюу Засгийн газраас санхүүждэг байгууллагын албан тушаалтан, ажилтан тамхи үйлдвэрлэгчээс төлбөр, бэлэг буюу ажил үйлчилгээ, мөнгөн болон мөнгөн бус хэлбэрийн дэмжлэг авахыг хориглоно.
- 4.11 Үндэсний хууль тогтоомж, Үндсэн хуулийн зарчмыг харгалзан Оролцогч талууд нь тамхи үйлдвэрлэгч буюу тамхи үйлдвэрлэгчийн эрх ашгийн төлөө ажиллаж буй аливаа хуулийн этгээдээс улс төрийн нам, нэр дэвшигч буюу кампанит ажилд хандив тусламж авахыг хориглох,



хандив тусламжийн талаар бүрэн мэдээлэхийг шаардах үр дүнтэй арга хэмжээ зохион байгуулна.

#### **(5) Тамхи үйлдвэрлэгчээс үнэн зөв, ил тод мэдээлэл өгөхийг шаардах**

Тамхи үйлдвэрлэгч нийгмийн эрүүл мэндийн бодлогод хөндлөнгөөс оролцохоос сэргийлэх үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэхийн тулд Оролцогч талуудад тамхи үйлдвэрлэгчийн үйл ажиллагааны талаар мэдээлэл шаардлагатай бөгөөд энэ нь тамхи үйлдвэрлэгчийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангахад ач холбогдолтой.

Конвенцийн 20.4 дүгээр зүйлд Оролцогч талууд тамхи үйлдвэрлэгчийн үйл ажиллагаа, тамхины тариалангийн талаар болон бусад чиглэлээр мэдээлэл солилцохыг эрчимжүүлэх, дэмжих шаардлагатай болохыг заасан байдаг. Конвенцийн 20.4 (с) дүгээр зүйлийн хүрээнд Оролцогч тал бүр Конвенцийн болон үндэсний тамхины хяналтын үйл ажиллагаанд нөлөө үзүүлэх тамхи үйлдвэрлэгчдийн үйл ажиллагаа, тамхины үйлдвэрлэлийн талаарх мэдээллийг тогтмол цуглуулах, түгээх дэлхийн хэмжээний тогтолцоог яаралтай бий болгох, бэхжүүлэх талаар холбогдох олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах шаардлагатай.

#### **Зөвлөмж**

- 5.1 Оролцогч талууд тамхи үйлдвэрлэгчийн бүхий л үйл ажиллагаа, хэрэгжүүлж буй арга хэмжээг ил тод болгох арга хэмжээг нэвтрүүлэх, хэрэгжүүлэх шаардлагатай.<sup>3</sup>
- 5.2 Оролцогч талууд тамхи үйлдвэрлэгч, тэдний ашиг сонирхлын төлөө ажиллаж буй этгээдийг тамхи үйлдвэрлэл, зах зээлийн хувьцаа, зардал, орлого болон лобби, хүмүүнлэгийн үйл ажиллагаа, улс төрийн хандив дэмжлэг зэрэг бусад үйл ажиллагаа, Конвенцийн 13 дугаар зүйлд хориглоогүй болон хараахан хориглоогүй байгаа бусад арга хэмжээний талаар тогтмол мэдээллээр хангахыг шаардана.<sup>3</sup>
- 5.3 Оролцогч талууд тамхи үйлдвэрлэгч аж ахуйн нэгж, тэдгээрийг төлөөлөгч хамтран ажиллагч байгууллага, хувь хүн зэрэг лобби хийгчдийг бүртгэх, мэдээлэх журамтай байна.
- 5.4 Оролцогч талууд нь ташаа, бодит бус мэдээлэл өгсөн тохиолдолд тамхи үйлдвэрлэгчид үндэсний хууль тогтоомжийн дагуу зохих хариуцлага хүлээлгэнэ.
- 5.5 Оролцогч талууд нь Конвенцийн 12(с) дугаар зүйлийн дагуу Конвенцийн зорилгод нийцүүлэн олон нийтийн сангаас мэдээлэл авах зэрэг тамхи үйлдвэрлэгчийн үйл ажиллагааны талаар өргөн хүрээтэй мэдээлэл авах боломжоор олон нийтийг хангах үүднээс хууль тогтоох, гүйцэтгэх, захиргааны болон бусад арга хэмжээг батлан хэрэгжүүлнэ.

#### **(6) Тамхи үйлдвэрлэгчийн зүгээс "нийгмийн хариуцлага"-тай хэмээн тодотгосон үйл ажиллагаа явуулахыг буруушаах, зохицуулах**

Тамхи үйлдвэрлэгчид нь үйлдвэрлэн худалдаалж байгаа бүтээгдэхүүний үхэлд хүргэх хор уршгаас өөрсдийгөө зайлуулах буюу буюу нийгмийн эрүүл мэндийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцох зорилгоор “нийгмийн хариуцлага”-тай үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Тамхи үйлдвэрлэгчийн

<sup>3</sup> Худалдааны нууц, хуулиар хамгаалагдсан нууц мэдээлэлд халдахгүй.

“нийгмийн хариуцлага” гэж тодорхойлдог үйл ажиллагаа нь тамхины хэрэглээг дэмжихэд чиглэгдсэн маркетинг байдаг. Мөн энэхүү үйл ажиллагаа нь Конвенц дахь тамхин бүтээгдэхүүний сурталчлах, дэмжлэг үзүүлэх, ивээн тэтгэх үйл ажиллагааны тодорхойлолтод хамаарах олон нийттэй харилцах стратеги юм.

Тамхи үйлдвэрлэгчдийн үндсэн үйл ажиллагаа нь тамхины хяналтын талаарх талаарх нийгмийн эрүүл мэндийн бодлогын зорилтуудтай зөрчилддөг тул Дэлхийн эрүүл мэндийн тодорхойлсноор тамхи байгууллагын үйлдвэрлэгчийн “нийгмийн хариуцлага” нь зөрчилт талыг агуулж байдаг.<sup>4</sup>

### **Зөвлөмж**

- 6.1 Оролцогч талууд нь засгийн газрын бүх салбар, олон нийтэд тамхи үйлдвэрлэгчийн “нийгмийн хариуцлагатай” гэсэн тодотголтой үйл ажиллагааны зорилго, цар хүрээний талаар ойлгуулж, мэдээлэл өгөх шаардлагатай.
- 6.2 Оролцогч талууд тамхи үйлдвэрлэгчийн “нийгмийн хариуцлага”-тай хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх, батлахыг хориглоно.
- 6.3 Оролцогч талууд тамхи үйлдвэрлэгч, тэдний ашиг сонирхлын төлөө ажиллаж буй этгээд нь жилийн үйл ажиллагааны тайлан зэрэг хуулийн дагуу зарцуулсан зардлын талаар тайлагнахаас бусад тохиолдолд “нийгмийн хариуцлага”-тай үйл ажиллагаа болон эдгээр арга хэмжээний зардлын талаар олон нийтэд мэдээлэхийг хориглоно.<sup>5</sup>
- 6.4 Оролцогч талууд нь хуулийн заалт, хуулиар олгогдсон эрх, хүлээсэн үүрэг, гэрээнд заагдсан үүрэг биелүүлэхээс бусад тохиолдолд засгийн газар болон улсын салбар тамхи үйлдвэрлэгч, тэдний ашиг сонирхлын төлөө ажиллаж буй этгээдээс улс төр, нийгэм, боловсрол, санхүүгийн болон бусад дэмжлэг авахыг хориглоно.

## **(7) Тамхи үйлдвэрлэгчид давуу эрх олгохгүй байх**

Зарим засгийн газар нь хуулийн дагуу төлөх ёстой татвараас бүрэн буюу хэсэгчлэн чөлөөлөх зэргээр санхүүгийн хөшүүрэг бий болгож тамхи үйлдвэрлэгчийн хөрөнгө оруулалтыг дэмждэг.

Эдийн засаг, санхүү, санхүү, татварын бодлогоо тодорхойлох, хэрэгжүүлэх бүрэн эрхтэй. Оролцогч талууд тамхины хяналтын талаар хүлээсэн үүрэг хариуцлагаа хүндэтгэн хэрэгжүүлэх шаардлагатай.

### **Зөвлөмж**

- 7.1 Оролцогч талууд тамхи үйлдвэрлэгчид үйл ажиллагаа эрхлэх, эхлүүлэхэд нь урамшуулал, давуу эрх олгохгүй.
- 7.2 Төрийн эзэмшлийн тамхи үйлдвэрлэгчгүй Оролцогч талууд тамхины үйлдвэрлэл, бусад холбогдох үйлдвэрт хөрөнгө оруулахыг хориглоно. Төрийн эзэмшлийн тамхи үйлдвэрлэгчтэй Оролцогч талууд нь тамхины үйлдвэрлэгчид оруулах аливаа хөрөнгө оруулалт нь Тамхины хяналтын суурь конвенцийг бүрэн хэрэгжүүлэхэд саад болохгүй байх нөхцөлийг хангана.

<sup>4</sup> WHO. *Tobacco industry and corporate social responsibility - an inherent contradiction*. Geneva, World Health Organization, 2004

<sup>5</sup> ДЭМБ-ын Тамхины хяналтын суурь конвенцийн 13 дугаар зүйлийг хэрэгжүүлэх удирдамжид үүнийг тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагаатай адилтган авч үздэг.

7.3 Оролцогч талууд нь тамхи үйлдвэрлэгчид татварын хөнгөлөлтийн давуу тал олгохгүй.

#### **(8) Төрийн эзэмшлийн тамхи үйлдвэрлэгчид бусад тамхи үйлдвэрлэгчийн нэгэн адил хандах**

Тамхи үйлдвэрлэгч нь засгийн газрын, засгийн газрын бус эзэмшлийн буюу холимог хэлбэртэй байж болно. Энэхүү удирдамж нь тамхи үйлдвэрлэгчийн эзэмшлээс үл хамааран бүх тамхи үйлдвэрлэгчид хамаарна.

##### **Зөвлөмж**

- 8.1 Оролцогч талууд нь тамхины хяналтын бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд төрийн эзэмшлийн тамхи үйлдвэрлэгчтэй бусад тамхи үйлдвэрлэгчийн нэгэн адил хандана.
- 8.2 Оролцогч талууд нь тамхины хяналтын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг тамхи үйлдвэрлэгчийг удирдан зохион байгуулах, хяналт тавихаас тусад нь байлгана.
- 8.3 Оролцогч талууд нь төрийн эзэмшлийн тамхи үйлдвэрлэгчийг талуудын хурал, түүнийг төлөөлөх байгууллага, Оролцогч талуудын Бага хурлын шийдвэрээр байгуулагдсан ажлын хэсэг, бүлгийн уулзалтын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд оролцуулахыг хориглоно.

## **ХЭРЭГЖИЛТ БА ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ**

### **Хэрэгжилт**

Оролцогч талууд нь Конвенцийн 5.3 дугаар зүйл болон энэхүү удирдамжийн хүрээнд хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх механизмыг бий болгох буюу боломжтой бол хэрэгжилтийн өнөөгийн механизмыг ашиглана.

### **Конвенцийн 5.3 дугаар зүйл болон энэхүү удирдамжийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ**

Конвенцийн 5.3 дугаар зүйл болон энэхүү удирдамжийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ нь тамхины хяналтын үр дүнтэй бодлогыг нэвтрүүлэх, хэрэгжүүлэхэд нэн чухал. Үүний тулд ДЭМБ-ын Тамхинаас ангид байх санаачилгын тамхи үйлдвэрлэгчийн мэдээний сан зэрэг аргачлал, нөөцийг ашиглаж тамхи үйлдвэрлэгчийн хяналт-шинжилгээг хийнэ.

Тамхи үйлдвэрлэгчтэй холбоогүй төрийн бус байгууллагууд болон Нийгмийн иргэний байгууллага үйлдвэрлэгчийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийхэд чухал үүрэг гүйцэтгэнэ.

Засгийн газрын бүх салбарын ажилтнуудын журам, ёсзүйн дүрэм нь “шүгэл үлээх” болон мэдээлэгчийг хамгаалах асуудлыг тусгасан байх шаардлагатай. Мөн омбудсманы тогтолцоо гэх мэтийн гомдол гаргах, шүүхээр хэлэлцэх зэрэг энэхүү удирдамжийн хэрэгжилтийг хангах механизмыг ашиглах, хэрэгжүүлэхэд Оролцогч талуудад дэмжлэг үзүүлнэ.

## **ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА, УДИРДАМЖИЙГ ШИНЭЧЛЭХ, ӨӨРЧЛӨХ**

Тамхины хяналтын талаарх нийгмийн эрүүл мэндийн бодлогыг боловсруулахад тамхи үйлдвэрлэгчийн хөндлөнгийн оролцооноос сэргийлэх талаар ахиц дэвшил гаргахад олон улсын хамтын ажиллагаа чухал. Конвенцийн 20.4 дүгээр зүйл нь хөгжиж буй болон шилжилтийн эдийн засгийн үед байгаа Оролцогч талуудын өвөрмөц хэрэгцээг харгалзан тамхи үйлдвэрлэгчийн үйл ажиллагааны талаар мэдлэг, туршлага солилцох, хуримтлуулах нөхцөл бүрдүүлж өгдөг.

Тамхи үйлдвэрлэгчийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, тамхи үйлдвэрлэгчийн ашигладаг стратеги, аргуудтай холбоотой олон улсын болон үндэсний туршлагыг түгээх, хуримтлуулах асуудлыг зохицуулах талаар тодорхой үйл ажиллагаа хийгдэж байна. Оролцогч талууд нь тамхи үйлдвэрлэгчийн стратегид хариу арга хэмжээ авах талаар хууль эрх зүйн болон стратегийн туршлагаа хуваалцах нь ач холбогдолтой зүйл юм. Конвенцийн 21.4 дүгээр зүйлийн дагуу мэдээлэл солилцох үйл ажиллагаа нь нууцлал, аюулгүй байдлын талаарх үндэсний хууль тогтоомжийн хүрээнд явагдана.

### **Зөвлөмж**

Тамхи үйлдвэрлэгчийн стратеги, арга тасралтгүй өөрчлөгдөж байгаа тул тамхины хяналтын талаарх нийгмийн эрүүл мэндийн бодлогыг тамхи үйлдвэрлэгчийн хөндлөнгийн оролцооноос хамгаалах үр дүнтэй аргачлалаар Оролцогч талуудыг хангах үүднээс энэхүү удирдамжид тогтмол үнэлгээ дүгнэлт хийж, өөрчлөлт оруулж байх шаардлагатай.

Оролцогч талууд нь Конвенцийн тайлагналтын арга механизмын дагуу тамхины үйлдвэрлэл, Конвенцийн хэрэгжилт болон үндэсний тамхины хяналтын үйл ажиллагаанд сөргөөр — нөлөөлж болзошгүй арга хэмжээний талаар мэдээллээр хангана. Харилцан мэдээлэл солилцох үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд Конвенцийн Нарийн бичгийн дарга нарын газар нь Оролцогч талуудын Бага хурлаас Оролцогч талуудын хэрэгцээнд зориулан тайлагналтын механизмыг боловсронгуй болгож, түүндээ энэхүү аргачлалын үндсэн заалтуудыг тусгана.

Тамхины хяналтын асуудлаарх нийгмийн эрүүл мэндийн бодлогод тамхины үйлдвэрлэгчийн оролцооноос урьдчилан сэргийлэх арга хэмжээний ач холбогдлыг харгалзан, энэхүү аргачлалыг хэрэгжүүлсэн туршлагад үндэслэн Конвенцийн 5.3 дугаар зүйлийг хэрэгжүүлэх протокол байгуулах эсэх асуудлыг авч үзэх шаардлагатай.

## **МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖ**

### **Номзүй**

Brandt AM. The cigarette century. The rise, fall, and deadly persistence of the product that defined America. New York, Basic Books, 2007.

Chapman S. Making smoking history. Public health advocacy and tobacco control. Oxford, Blackwell Publishing, 2007.

Callard C, Thompson D, Collishaw N. Curing the addiction to profits: a supplyside approach to phasing out tobacco. Ottawa, Canadian Centre for Policy Alternatives and Physicians for a Smoke free Canada, 2005.

Feldman EA, Bayer R (Editors). Unfiltered: conflicts over tobacco policy and public health. Boston, Harvard University Press, 2004.

Gilmore A et al. Continuing influence of tobacco industry in Germany. Lancet, 2002, 360:1255.

Hastings G, Angus K. The influence of the tobacco industry on European tobacco control policy. In: Tobacco or health in the European Union. Past, present and future. Luxembourg, Office for Official Publications of the European Commission, 2004:195-225.

Lavack A. Tobacco industry denormalization campaigns: a review and evaluation. Ottawa, Health Canada, 2001.

Mahood G. Tobacco industry denormalization. Telling the truth about the tobacco industry's role in the tobacco epidemic. Toronto, Campaign for Tobacco Industry Denormalization, 2004.

Pan American Health Organization. Profits over people. Tobacco industry activities to market cigarettes and undermine public health in Latin America and the Caribbean. Washington DC, Pan American Health Organization, 2002.

Simpson D. Germany: still sleeping with the enemy. Tobacco Control, 2003, 12:343-344.

Hammond R, Rowell A. Trust us. We're the tobacco industry. Baltimore, Johns Hopkins University Press, 2001.

World Health Organization. Tobacco company strategies to undermine tobacco control activities at the World Health Organization. Geneva, World Health Organization, 2000.

World Health Organization. Tobacco industry and corporate social responsibility - an inherent contradiction. Geneva, World Health Organization, 2004.

Ar Yach D, Bialous S. Junking science to promote tobacco. American Journal of Public Health, 2001, 91:1745—1748.

## **Вэб дээрх мэдээлэл**

### *ДЭМБ-ын вэб хуудас:*

Тамхинаас ангид байх санаачилга:

[https://www.who.int/health-topics/tobacco#tab=tab\\_1](https://www.who.int/health-topics/tobacco#tab=tab_1)

Тамхины асуудлаарх ДЭМБ-ын хэвлэл:

<https://www.who.int/publications/i?healthtopics=4f9c28ef-e67e-4ce6-b64c-817831e9bea9&publishingoffices-hidden=true>

ДЭМБ-ын Европын бүсийн төв:

[https://www.who.int/europe/health-topics/tobacco#tab=tab\\_1](https://www.who.int/europe/health-topics/tobacco#tab=tab_1)

Америк дахь тамхины хяналт (англи, испани хэлээр):

<https://www.paho.org/en/topics/tobacco-control>

***Тамхины хяналтын талаарх ерөнхий мэдээлэл:***

Тамхи ба эрүүл мэндийн санаачилга, Их Британи (тамхин үйлдвэрлэлийн талаар тусгай мэдээлэлтэй):

[http://www.newash.org.uk/ash\\_r3iitasl.htm](http://www.newash.org.uk/ash_r3iitasl.htm)

Нийгмийн хариуцлагыг сүлжээ: [www.stopcorporateabuse.org](http://www.stopcorporateabuse.org)

Тамхины хяналтын эдийн засаг: <http://www1.worldbank.org/tobacco/>

Европын холбоо:

[http://ec.europa.eu/health/ph\\_determinants/life\\_style/Tobacco/tobacco/en.htm](http://ec.europa.eu/health/ph_determinants/life_style/Tobacco/tobacco/en.htm)

Тамхины хор уршгаас сэргийлэх Европын сүлжээ: <http://www.ensp.org/>

Тамхины хяналтын суурь конвенцийн холбоо: <http://www.fctc.org/>

Эрүүл мэндийг дэмжих, эрүүл мэндийн боловсролын олон улсын холбоо:

<http://www.iuhpe.org/?page=18&lang=en>

Тамхины хяналтын загвар хуулийн гарын авлага:

[http://www.iuhpe.org/?lang=en&page=publications\\_report2](http://www.iuhpe.org/?lang=en&page=publications_report2)

Тамхины үйлдвэрлэл:

<http://tobacco.health.usyd.edu.au/site/supersite/links/docs/tobaccoind.htm>

Тамхинаас ангид түншлэл: <http://www.smokefreepartnership.eu/>

Тайландын эрүүл мэндийг дэмжих хүрээлэн: <http://www.thpinhf.org>

Тобакопеди: тамхины онлайн нэвтэрхий толь: <http://www.tobaccopedia.org/>

***Тамхины талаар бусад вэб хуудас:***

Тамхины хяналтын асуудлаарх олон улсын ба үндэсний вэб хуудаснууд:

<http://www.tobacco.org/resources/general/tobsites.html>

Тамхины хяналтын асуудлаарх үндэсний вэб хуудаснууд:

<http://www.smokefreepartnership.eu/National-Tobacco-Control-websites>

Тамхины эсрэг нөөцийн төв: <http://www.tabac-info.net/>

Тамхитай тэмцэх үндэсний хороо (Франц): <http://www.cnct.org>

Тамхины хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх Францын төв: <http://www.offt-asso.fr/>

Тамхины хяналтын талаар сүүлийн үеийн мэдээлэл: <http://www.globalink.org/news/fr>

Эрүүл мэнд, спортын яам (Франц): <http://www.sante.gouv.fr/>

Тамхины хяналтын талаар сүүлийн үеийн мэдээлэл: <http://www.globalink.org/news/es>